

## Шилэн кабель татах ажлын техникийн

### болон ажлын даалгавар

МУИС-ийн 2026 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдаж, холбогдох төсөв нь батлагдсан ажлын хүрээнд МУИС-ийн төв зангилаа (Номын сангийн байр)-г Монголын Интернэт Урсгалын Нэгдсэн Солилцооны Төв (MISPA-IX)-тэй холбох 8 кор бүхий шилэн кабелийн шугамыг татан суурилуулах ажлыг гүйцэтгэнэ. Энэхүү ажлын хүрээнд хэрэгжүүлэх техникийн шаардлага, ажлын даалгавар болон гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг доор тусгав.

#### Гүйцэтгэгч тал дараах шаардлагыг хангасан байна:

- Шилэн кабель татах байгууллага нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй, тухай чиглэлээр ажил гүйцэтгэж байсан туршлагатай, харилцааны холбоо тухайн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Улаанбаатар хотод агаарын болон сувагчлалын хүрээнд шилэн кабель татах тусгай зөвшөөрөлтэй байна.
- Шилэн кабель татаж байсан туршлагатай байх, шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинтэй байх.
- Шилэн кабелийн залгааны машин, кабелийн ролик, кабелийг тэмдэгжүүлэх хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хэрэгсэл, телешк, цахилгаан үүсгүүр, кран бүхий машин механизм болон шилэн кабель татахад шаардлагатай бусад тоног төхөөрөмжтэй байх.
- Нийлүүлэгч тал тоног төхөөрөмжийг суурилуулах ажиллагаанд оруулах ажлыг бүрэн хариуцан хийнэ.
- Гүйцэтгэсэн ажлын шилэн кабелийн гэмтлийг засах, үйлчилгээ үзүүлэх боломжтой байх.

1. Шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт үзүүлэлтийг хүснэгт №1 харуулав.

#### Хүснэгт №1. Төхөөрөмжийн жагсаалт, техникийн шаардлага

№	Тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага
1	Шилэн кабель (8 кор)	Метр	2000	<ul style="list-style-type: none"><li>• Олон улсын стандартад нийцсэн</li><li>• Гадна зориулалттай, тусгай хамгаалалтай</li><li>• Хэрэглээ: Агаарын баганаар суурилуулах</li><li>• <b>Шөрмөсний тоо:</b> 8 кор</li><li>• <b>Шөрмөсний төрөл:</b> Нэг модуль Single mode</li><li>• <b>Шөрмөсний стандарт:</b> G652D</li><li>• Багана дээр бэхлэх бат бэх ган тросстой</li><li>• Температур 40C – +70C</li></ul>
2	8 кор FDF (FDF -4 –SC Rack mount дүйцэхүйц)	Ширхэг	2	<ul style="list-style-type: none"><li>• Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж</li><li>• Раканд суурилуулах, шороо тоосны хамгаалалттай</li><li>• Пигтайл, адаптер, гильз</li><li>• Зэвэрдэггүй хайлш</li></ul>
3	Jumper cable 4 метр	Ширхэг	2	
4	Оптик модуль 10G	Ширхэг	2	<ul style="list-style-type: none"><li>• 10Gbps - SFP+</li></ul>

2. МУИС-ийн төв зангилааг (Номын сангийн байр) Монголын интернэт урсгалын нэгдсэн төв сүлжээнд (Mispa – DC 2 дата центр) холбох шилэн кабелийг сувагчлалаар Зураг №1 үзүүлснээр татаж, 2 талын байрлалд цэнэглэх корын тоо 8 байна.



Зураг №1. Шилэн кабель татах зураглал

Техникийн шаардлага гаргасан:.....*Н. Золбаяр*...../ЦШБГ, Администратор Н.Золбаяр/